



# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа  
Утас: 7036-3040  
Цахим хаяг: ch.enkh@yahoo.com

Аудитын менежер Б.Батмөнх  
Утас: 7036-3047  
Цахим хаяг: ba\_batmunkh@yahoo.com

Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ  
Багийн гишүүд  
Ахлах аудитор Б.Наранчимэг  
Аудитор Б.Эрдэнэзул  
Ц.Отгонбаяр  
Шинжээч С.Баасансүрэн  
А.Дашбат

Утас: 7036-2442  
Цахим хаяг:  
Sbaterdene991@yahoo.com

**ТАБ-ын хаяг:** УАГ-ын харьяа Сэлэнгэ  
аймгийн Аудитын газар

**Байршил:** АЗДТГ-ын байрны  
өргөтгөлд

**Цахим хуудас:**  
[www.Selenge@audit.gov.mn](http://www.Selenge@audit.gov.mn)

**2015 оны 3 дугаар сар**

## Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Менежментийн захидал

Хавсралт 5: Санхүүгийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## **1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

МУ-ын Төсвийн тухай хуулийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэхь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн /ТЕЗ/төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд СЭЛ/2015/01-СТА-ТЕЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийхээр төлөвлөн Сэлэнгэ аймгийн Аудитын газрын Ахлах аудитор С.Бат-Эрдэнэ хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

## **2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

ТЕЗ нь Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай”, “Төрийн албаны тухай”, “Төсвийн тухай”, Татварын тухай багц хууль, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “ТБОНӨХБАУ худалдан авах тухай” хууль болон холбогдох бусад хуулиуд, Засгийн газрын тогтоол, харьяа яамдын сайдын тушаалууд, аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан дүрэм, журмуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд төсвийн байгууллагад мөрдөгдөх “Дансны жагсаалт батлах тухай” Сангийн сайдын 2005 оны 276 дугаар тушаалыг 2014 оны 05 дугаар тушаалаар хүчингүй болгож, зардлын эдийн засгийн ангилал болон балансын дансны жагсаалтыг шинэчлэн баталсныг мөрдөөгүй байна.

## **3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Аймгийн Засаг дарга нь МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8-р зүйлийн 8.1 “ *Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал,*

үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална” гэсэн зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх гэсэн 14 дүгээр зүйлийн 14.1.17-д “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн” гэж заасны дагуу аймгийн Засаг дарга С.Бүрэнбат Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд Сангийн яам болон, Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс зохих хяналтыг хэрэгжүүлж байна.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

#### **4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 10-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2014 онд Санхүү, төрийн сангийн үйл ажиллагааны бодлогын баримт бичиг, Сэлэнгэ аймгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулан, баталж, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “**Plastic**” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### **5. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дунд байна.

#### **6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн төсвийн багцын байгууллагуудын 2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сан дахь харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2014 оны 12-р сарын 22-ны өдрийн 60 дугаар тогтоолоор төсвийн нийт орлого, зарлагыг **67,890.2 сая** төгрөгөөр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр 2014 онд орон нутгийн төсвийн орлого 15,644.9 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 16,816.9 сая төгрөг буюу 7.5 хувиар давж биелэсэн байна. Мөн улсын төсвөөс 4,645.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 6,634.0 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн санхүүжилтийг, тусгай зориулалтын байгууллагуудын санхүүжилтэнд 39,284.9 сая төгрөгийн зэрэг нийт **67,380.9 сая** төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн зарцуулжээ.

Орон нутгийн төсвийн зарлага 28,502.0 сая төгрөгийн буюу 88.6 сая төгрөгийн, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд 39,053.1 сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлтэй гарсан байна.

Орон нутгийн төсвийн зарлагын 68.2 хувийг урсгал зардалд, 31.8 хувийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлагын 69 хувийг цалин, НДШ-ийн, 24 хувийг бусад бараа үйлчилгээний зардалд, 7 хувийг тусламж, урамшууллын зардал эзэлж байна.

## **7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж орон нутгийн төсөвт байгууллагууд үндсэн мэдээлэл болон 2015 оны төсвийн хуваарийг оруулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад мэдээлж байна.

## **8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ 51 хүртэлх эрсдэлийг тооцож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 хүртэлх нарийвчилсан горим, сорил гүйцэтгэсэн байна.

**Үр дагавар:** Аудитын явцад нийт 5,634.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, материаллаг хэмжээний 2,188.2 сая төгрөгийн, материаллаг бус 3,446.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Үүнээс: Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой 3,176.3 сая төгрөгийн алдааг залруулж, 45.3 сая төгрөгийн зөрчилд хөрөнгө нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 1,976.2 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага, 436.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

## **9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 17 сумын орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллага, ангилагдаагүй зардал, замын сан, ОНХС зэрэг тусгай сан, ОНӨААТҮГазруудын санхүүгийн тайлангууд нэгтгэгдсэн байна. Үүнд: Аймаг, сумдын орон нутгийн төсөвт 103, тусгай зориулалтын шилжүүлгийн 130 төсөвт байгууллага, 32 төсөл сан, орон нутгийн өмчит 11 аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитаар Орхонтуул, Ерөө, Түшиг, Хушаат, Зүүнбүрэн зэрэг 5 сумын ТЕЗ-ийн, Аймгийн ИТХ, Номгон тосгоны цэцэрлэг, Сүхбаатар сумын 3-р цэцэрлэг зэрэг 4 ТШЗ-ийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай-санал дүгнэлт”, Цагааннуур сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Түнхэл тосгоны сургууль, цэцэрлэг, Цагааннуур сумын сургууль зэрэг 3 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг-санал дүгнэлт”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Татгалзсан санал дүгнэлт” өгч, 12 сумдын ТЕЗ, 57

ТШЗахирагч, 9 ОНӨААТҮГазрын санхүүгийн тайланд “Зөрчилгүй-санал дүгнэлт”-ийг өгсөн байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг нотлох үүднээс аудитор түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлын дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгаж, ажлын баримтыг файл үүсгэн хадгалсан болно.

## **10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

### **10.1 Аймаг, сумдын төсвийн байгууллагуудын болон ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар:**

#### **Үр дагавар:**

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын явцад нийт 4,044.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, материаллаг хэмжээний 995.4 сая төгрөгийн, материаллаг бус 3,049.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Үүнээс: Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой 3,049.3 сая төгрөгийн алдааг залруулж, 42.9 сая төгрөгийн зөрчилд хөрөнгө нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 802.3 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 150.2 сая төгрөгийн зөвлөмж өгөв.

#### **Материаллаг хэмжээний дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:**

1. ТЕЗ-ийн багцад хамаарах орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг нийт 1.9 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчиж байна. Үүнд:

- ✓ Алтанбулаг сумын соёлын төв 0.5 сая төгрөгөөр,
- ✓ Мандал сумын Түнхэл тосгоны соёлын төв 0.1 сая төгрөгөөр,
- ✓ Орхон сумын соёлын төв 0.9 сая төгрөгөөр,
- ✓ Жавхланта сумын ЗДТГ 0.4 сая төгрөгөөр,

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

2. ИХШХГ-ын визийн улсын тэмдэгтийн хураамжийн 300.1 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт бус орон нутгийн төсөвт төвлөрүүлэн зарцуулсан нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.9, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтуудыг зөрчиж байна. Үүнд:

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

3. Газрын болон усны төлбөрийн 17.6 сая төгрөгийг аймгийн төсөвт бус сумдын төсөвт төвлөрүүлэн зарцуулсан нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 23.7 “Аймаг, нийслэлийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.6.2. газрын төлбөр”, Газрын төлбөрийн тухай хуулийн 4-р зүйлийн “Газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа, Газрын тухай

хуулийн 10 дугаар зүйлд заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах болон тусгай хэрэгцээний газарт төлбөр ногдуулна”, Газрын тухай хуулийн 11-р зүйлийн 11.1. “Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна” гэсэн заалтуудыг зөрчиж байна. Үүнд:

- ✓ Баянгол сум хадлангийн болон газар эзэмших төлбөрийн 13.6 сая төгрөгийн орлогыг,
- ✓ Орхонтуул сум хадлангийн төлбөрийн 1.1 сая төгрөгийн орлогыг,
- ✓ Сайхан сум 2.5 сая төгрөгийн газрын төлбөрийн, 0.4 сая төгрөгийн усны төлбөрийн орлогыг,

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

4. Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр болон хууль бусаар бэлтгэсэн модны дуудлага худалдааны орлого зэрэг 14.4 сая төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлэлгүйгээр сум дундын Ойн ангийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна. Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 23-р зүйлийн 8.7 дахь сумын төсвийн орлого нь “ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр”-өөс бүрдэнэ, 9-р зүйлийн 9.2 дахь “ сумын төсвийн татварын бус орлого нь “орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого хүү, торгуулийн орлогоос бүрдэнэ” гэсэн заалтуудыг зөрчиж байна. Үүнд:

- ✓ Хүдэр сумын Ойн анги хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн 2.6 сая төгрөг, хууль бусаар бэлтгэсэн мод хураан авч дуудлага худалдаагаар борлуулсны 8.2 сая төгрөгийн орлогыг ойн ангийн арилжааны банк дахь дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.
- ✓ Цагааннуур сумын сум дундын Ойн анги хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн 2.3 сая төгрөгийн орлогыг авч 1.3 сая төгрөгийг зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Гоожингийн орлого 2.6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож, бусад алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

5. Орхонтуул сумын төсөвт байгууллагууд 1.8 сая төгрөгийн өөрийн орлогыг ИТХ-аар батлуулахгүйгээр шууд зарцуулснаас батлагдсан төсвийг энэ хэмжээгээр хэтрүүлсэн нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага болон зөвлөмж хүргүүлээ.

6. Хандив тусламжийн болон өөрийн орлогын нийт 11.9 сая төгрөгийг төрийн сангийн бүртгэлийн дансаар дамжуулалгүйгээр кассаар зарцуулж, санхүүгийн тайланд дутуу тусгасан байна. Энэ нь МУ-ын Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.13 “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын тооцоог гаргаж, тайланг тушаана” гэсэн заалтыг зөрчиж байна. Үүнд:

- ✓ Мандал сумын төсвийн байгууллагууд 6.5 сая төгрөг,
- ✓ Хүдэр сум ЗДТГ 2.3 сая төгрөг,
- ✓ Сайхан сумын Номгон тосгоны цэцэрлэг 3.1 сая төгрөг.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв

7. Төрийн сангийн бүртгэлийн данснаас хуурамч баримт бүрдүүлэн ажилтнуудын хувийн харилцах дансаар дамжуулан нийт 7.6 сая төгрөгийг бэлэн авч зарцуулсан байна. Энэ зөрчил нь МУ-ын Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.1 дэхь *“төсөвт байгууллага нь Төрийн сангийн бүртгэлийн данснаас байгууллагын төлбөрийн картын дансаар дамжуулан бэлэн мөнгийг байгууллагын касст хүлээн авч зориулалтын дагуу зарцуулах үүргийг хүлээнэ”, 3.2 “мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ”* гэсэн заалтуудыг зөрчиж байна. Үүнд:

- ✓ Цагааннуур сумын ЕБСургууль захирал, нягтлан бодогч болон багш , ажилчдын хувийн харилцах дансаар дамжуулан нийт 6.5 сая төгрөгийг бэлэн авч зориулалтын бус зүйлд зарцуулсан
- ✓ Түшиг сумын ЗДТГазар 1.1 сая төгрөгийг нярвын дансаар дамжуулан бэлэн авч зарцуулсан ч кассын тайлан гаргаагүй,

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар менежментийн захидал болон албан шаардлага хүргүүлээ

8.Ерөө сум нь Сумын хөгжлийг дэмжих сангаас олгосон зээлийн эргэн төлөлт болох 100.0 сая төгрөгийг Төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэхгүйгээр ХААН банкин дахь харилцах данснаас 35.0 сая төгрөгийг сумын 90 жилийн ойн хандивт, 10.0 сая төгрөгийг музейн тохижилтонд, 49.0 сая төгрөгийг Ерөө сумын төвд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажилд зарцуулсан байна. Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 35.3 *“Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ”* гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн үлдэгдэл 6.0 сая төгрөгийг Төрийн санд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож, 94.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

9.Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд батлагдсан төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцэст 26.7 сая төгрөгийн авлага, 100.0 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ зөрчил нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”* гэсэн заалтыг зөрчиж байна. Үүнд:

- ✓ Аймгийн ИТХ 50.0 мянган төгрөгийн авлага, 1.7 сая төгрөгийн өглөг,
- ✓ ГХБХБГ 3.5 сая төгрөгийн авлага
- ✓ Алтанбулаг сумын төсөвт байгууллагууд 0.22 сая төгрөгийн авлага, 4.9 сая төгрөгийн өглөг
- ✓ Баруунбүрэн сумын төсөвт байгууллагууд 0.4 сая төгрөгийн авлага, 8.7 сая төгрөгийн өглөг,
- ✓ Баянгол сумын төсөвт байгууллагууд 0.3 сая төгрөгийн авлага, 7.1 сая төгрөгийн өглөг,
- ✓ Мандал сум / Түнхэл тосгоны сургууль, цэцэрлэг ороогүй / 4.8 сая төгрөгийн өглөг,
- ✓ Сант сумын ЕБС 1.6 сая төгрөгийн өглөг,
- ✓ Ерөө сумын төсвийн байгууллагууд 3.6 сая төгрөгийн авлага, 23.9 сая төгрөгийн өглөг,

- ✓ Шаамар сумын төсвийн байгууллагууд 0.7 сая төгрөгийн авлага, 0.7 сая төгрөгийн өглөг,
- ✓ Орхонтуул сумын төсвийн байгууллагууд 3.9 сая төгрөгийн авлага, 12.4 сая төгрөгийн өглөг,
- ✓ Түшиг сумын төсвийн байгууллагууд 0.3 сая төгрөгийн авлага, 1.2 сая төгрөгийн өглөг,
- ✓ Сайхан сумын төсвийн байгууллагууд 0.1 сая төгрөгийн авлага, 2.1 сая төгрөгийн өглөг,
- ✓ Сүхбаатар сумын төсвийн байгууллагууд 5.7 сая төгрөгийн авлага, 0.9 сая төгрөгийн өглөг,
- ✓ Цагааннуур сум / сургууль ороогүй / 2.1 сая төгрөгийн авлага, 3.0 сая төгрөгийн өглөг,
- ✓ Жавхлант сумын төсөвт байгууллагууд 1.9 сая төгрөгийн авлага, 3.6 сая төгрөгийн өглөг,
- ✓ Зүүнбүрэн сумын төсөвт байгууллагууд 1.2 сая төгрөгийн авлага, 19.3 сая төгрөгийн өглөг,
- ✓ Хушаат сумын төсөвт байгууллагууд 2.7 сая төгрөгийн авлага, 4.1 сая төгрөгийн өглөг,

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

**10.**Цагааннуур сумын бүрэн дунд сургуулийн зардал, санхүүжилт хангалттай хэмжээгээр батлагдаж, бүрэн санхүүжилт хийгдсэн байхад цалингийн зардлаас хөрөнгө худалдан авах, нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгох, цалингийн цэсний хөлийн дүнг бодит дүнгээс илүү болгож засварлаж зөрүүг хувийн харилцах дансаар дамжуулан авч ашиглах, үндэслэлгүй, хууль бус цалин, нэмэгдэл бодож ашиглах зэргээр цалингийн зардлаас 86.7 сая төгрөгийн зориулалт бус гүйлгээ хийж төсвийг зүй зохистой удирдаагүйгээс / *задаргааг тус сургуулийн аудитын тайланд дэлгэрэнгүй тусгав* / оны эцэст НДШ, ХХОАТ-ын 56.1 сая төгрөгийн, нормативыг хэтрүүлснээс 9.6 сая төгрөгийн үдийн цай, хоолны материалын зэрэг нийт 66.2 сая төгрөгийн өр төлбөр, 3.4 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар цалингийн зардлаас хувьдаа ашигласан 12.4 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, хөрөнгө худалдан авсан, зардал хооронд гүйлгэн зарцуулсан зэрэг 73.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, Цагааннуур сумын төрийн сангийн төлөөлөгч, сургуулийн захирал, нягтлан бодогч нарт Төсвийн тухай хуулийн 70.3 дахь зүйлийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн Засаг дарга, ТЕЗ-д хүргүүлж, аймгийн Цагдаагийн газарт шилжүүлэв.

**11.**Түнхэл тосгоны цэцэрлэгийн зөөлөн эдлэлийг сольж сайжруулах, угааж ариутгах тоног төхөөрөмж худалдан авахад зориулж Сангийн яамнаас 20.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлснийг бэлнээр авч зарцуулах зорилгоор хуурамч нэхэмжлэх бүрдүүлэн 12 сарын 26-нд Түнхэл тосгоны "Тайлжийн нуруу" ХХК-ний дансанд шилжүүлж, үүсэхгүй байх боломжтой 20.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8 дахь *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, НББ-ийн тухай хуулийн 20.1.4 дэхь *"Хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих"* гэсэн заалтыг зөрчиж байна.

Дээрх 20.0 сая төгрөгийн 19.0 сая төгрөгийг цэцэрлэгийн нярав бус эрхлэгч Т.Лхагважав бэлнээр авсан бөгөөд 1.0 сая төгрөгийг нь Тайлжийн нуруу компанид бэлэн мөнгө гаргасны шимтгэлд үндэслэлгүйгээр суутгуулсан нь Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалаар баталсан Төсөвт байгууллагын мөнгөн кассын

ажиллагааны журмын 3.1 дэхь” Төсөвт байгууллага нь төрийн сангийн бүртгэлийн данснаас байгууллагын төлбөрийн картын дансаар дамжуулан бэлэн мөнгийг байгууллагын касст хүлээн авч зориулалтын дагуу зарцуулах үүргийг хүлээнэ”. 3.2 дахь “ Мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Эрхлэгч Т.Лхагважавын “Тайлжийн нуруу” ХХК-иас бэлнээр хүлээн авсан 19.0 сая төгрөгийг төрийн сангийн хяналтаас гадуур зарцуулж, зөөлөн эдлэл худалдан авах 12.2 сая төгрөгийн, угаалгын машин авах 1.5 сая төгрөгийн, хивс авах 2.8 сая төгрөгийн гүйлгээг бэлнээр гүйцэтгэсэн нь дээрх журмын 6.3 дахь ” Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба төлбөрийн нийт дүн нь 300,0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд худалдан авсан гэх цагаан хэрэглэлийг тулган баталгаажуулалт хийхэд 3.0 сая төгрөгийн хөрөнгө дутсан болно.

12.2 сая төгрөгийн өртөг бүхий зөөлөн эдлэлийн худалдан авалтыг гүйцэтгэхдээ үнийн харьцуулалтын арга хэрэглэлгүйгээр иргэн Х.Цэрэннадмидтай шууд гэрээ байгуулан худалдан авсан гэж баримт бүрдүүлсэн нь МУ-ын ТБОНӨБАҮХА тухай хууль болон Засгийн газрын 2013 оны 68 тоот тогтоолоор баталсан “ ТБОНӨХБАҮХА ажиллагаанд мөрдөх журмын сонгоход баримтлах босго үнэ”-ийг зөрчиж , худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Ийнхүү нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн 20.0 сая төгрөгийн зарцуулалт нь бүхэлдээ холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл болсон байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хуурамч баримт бүрдүүлэн хувийн компаний дансаар дамжуулан их хэмжээний бэлэн мөнгө гарган өөрөө авч хууль бусаар зарцуулсан, төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн болон худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй цэцэрлэгийн эрхлэгч Т.Лхагважавт Төсвийн тухай хуулийн 70.3 дахь зүйлийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн Засаг дарга, ТЕЗ-д хүргүүлэв.

**12.Түнхэл тосгоны сургуулийн Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, гал тогоо тохижуулах, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж Сангийн яамнаас 20.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлснийг бэлнээр авч зарцуулах зорилгоор хуурамч нэхэмжлэх бүрдүүлэн 12 сарын 26-нд хувийн компаний дансанд шилжүүлж, үүсэхгүй байх боломжтой 20.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 6–р зүйлийн 6.4.8 дахь” Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 20.1.4 дэхь “ Хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих “ гэсэн заалтыг зөрчиж байна.**

Дээрх 20.0 сая төгрөгийг хувийн компаниар дамжуулан бэлнээр авч БНХАУ-ын Эрээн хотоос бараа, материал татах зэргээр ямар ч хяналтгүйгээр зарцуулсан нь Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалаар баталсан Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 3.1 дэхь” Төсөвт байгууллага нь төрийн сангийн бүртгэлийн данснаас байгууллагын төлбөрийн картын дансаар дамжуулан бэлэн мөнгийг байгууллагын касст хүлээн авч зориулалтын дагуу зарцуулах үүргийг хүлээнэ”. 3.2 дахь “ Мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Бараа материал, ширээ сандал, тоног төхөөрөмж зэрэг их хэмжээний үнийн дүн бүхий гүйлгээг бэлнээр гүйцэтгэсэн нь дээрх журмын 6.3 дахь ” Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба

*төлбөрийн нийт дүн нь 300,0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байна”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Ийнхүү нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн 20.0 сая төгрөгийн зарцуулалт нь бүхэлдээ холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл болсон байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хуурамч баримт бүрдүүлэн хувийн компаний дансаар дамжуулан их хэмжээний бэлэн мөнгө гарган авч хууль бусаар зарцуулсан, төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн сургуулийн захиралын үүргийг гүйцэтгэгч Ч.Оюунгэрэлд Төсвийн тухай хуулийн 70.3 дахь зүйлийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн Засаг дарга, ТЕЗ-д хүргүүлэв.

**13.** Урьд оны санхүүгийн тайланд тусгагдаагүй 2.0 сая төгрөгийн өглөгийг тайлант жилийн төсвөөс барагдуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7-р зүйлийн 1 дэхь *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтыг зөрчиж байна.

- ✓ Хушаат оны санхүүгийн тайланд тусгаагүй томилолтын 0.3 сая төгрөгийн өглөгийг барагдуулсан.
- ✓ Шаамар сумын ЗДТГ нь өмнөх оны 1.7 сая төгрөгийн халаалтын өглөгийг 2014 жилийн төсвөөс төлсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

**14.** Байгууллагын эзэмшилд бодитойгоор оршоогүй 7.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, материалыг хөрөнгийн дансанд бүртгэсэн нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 4.1.2 *“санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”*, 9.1 *“Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”* гэсэн заалтуудыг зөрчиж байна.Үүнд:

- ✓ Түшиг сумын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй 7.0 сая төгрөгийн хангамжийн материал, мал амьтад ,
- ✓ Шаамар сумын Дулаанхан тосгоны цэцэрлэгийн дансанд бүртгэлтэй 0.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө,

**Шийдвэрлэсэн нь:** Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар менежментийн захидал болон албан шаардлага хүргүүлээ.

**15.** Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагууд цалин хөлсийг давхардуулан олгох, тушаал шийдвэргүйгээр нэмэгдлүүд олгох, цалингийн санг бусад зардалд гүйлгэн зарцуулах, ХХОАТ, НДШ-ийн суутгалыг илүү, дутуу хийх, буруу тайлагнах зэрэг нийт **125.9 сая** төгрөгийн зөрчил гаргасан байна.Үүнд:

- ✓ Аймгийн ЗДТГ 2.5 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн ГХБХБГ 1.1 сая төгрөгийн,
- ✓ Сэлэнгийн долгио чуулга нь 1.5 сая төгрөгийн,
- ✓ Алтанбулаг сумын төсөвт байгууллагууд 3.1 сая төгрөгийн,
- ✓ Баруунбүрэн сумын төсөвт байгууллагууд 0.3 сая төгрөгийн,
- ✓ Мандал сумын төсвийн байгууллагууд 9.7 сая төгрөгийн,
- ✓ Ерөө сумын төсөвт байгууллагууд 10.6 сая төгрөгийн,
- ✓ Сант сумын төсөвт байгууллагууд 2.5 сая төгрөгийн,
- ✓ Сайхан сумын төсөвт байгууллагууд 2.4 сая төгрөгийн,
- ✓ Сүхбаатар сумын төсөвт байгууллагууд 47.7 сая төгрөгийн,
- ✓ Түшиг сумын төсөвт байгууллагууд 0.4 сая төгрөгийн,
- ✓ Орхон сумын төсөвт байгууллагууд 0.9 сая төгрөгийн,

- ✓ Орхонтуул сумын төсөвт байгууллагууд 24.6 сая төгрөгийн,
- ✓ Шаамар сумын төсөвт байгууллагууд 11.4 сая төгрөгийн,
- ✓ Хүдэр сумын төсөвт байгууллагууд 3.3 сая төгрөгийн,
- ✓ Жавхлант сумын ЗДТГ нь 1.6 сая төгрөгийн,
- ✓ Хушаат сумын ЗДТГ нь 2.3 сая төгрөгийн,

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

**16.** Дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр 37.2 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ зөрчил нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэхь “ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7-р зүйлийн 7.1 дэхь “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5-р зүйл, 6.1 дэхь заалтуудыг зөрчиж байна.Үүнд :

- ✓ Аймгийн ИТХ 0.4 сая төгрөгийн,
- ✓ Сэлэнгийн долгио чуулга нь 1.1 сая төгрөгийн,
- ✓ Алтанбулаг сумын төсөвт байгууллагууд 6.1 сая төгрөгийн
- ✓ Баянгол сумын төсөвт байгууллагууд 0.5 сая төгрөгийн
- ✓ Мандал сумын төсөвт байгууллагууд 10.8 сая төгрөгийн,
- ✓ Орхон сумын төсөвт байгууллагууд 0.1 сая төгрөгийн,
- ✓ Орхонтуул сумын төсөвт байгууллагууд 3.0 сая төгрөгийн,
- ✓ Хүдэр сумын төсөвт байгууллагууд 8.4 сая төгрөгийн,
- ✓ Цагааннуур сумын төсөвт байгууллагууд 2.4 сая төгрөгийн,
- ✓ Хушаат сумын төсөвт байгууллагууд 4.4 сая төгрөгийн,

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

**17.** Цагааннуур сумын ЗДТГазар халаалтын зардлыг бодит гүйцэтгэлээс 2.4 сая төгрөгөөр илүү шилжүүлсэн нь МУ-ын төсвийн тухай хуулийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2 “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн халаалтын зардлын 2.4 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, зөвлөмж өгөв.

**18.** ЕБС зарим сургуулиуд дотуур байрны хүүхдийн хоолны нормативт зардлыг хэтрүүлэн зарцуулсан, үдийн цайны цэсэнд чокопай, печень, чихэр, иштэй чихэр оруулж өгсөн, бараа материалыг зах зээлийн үнээс өндөр үнээр бэлтгэсэн зэрэг, нийт 13.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Эдгээр нь МУ-ын Засгийн газрын 2012 оны “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” 106 тоот тогтоолын 3 “ЕБС, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоолны зардлыг 2315 төгрөгөөр тогтоосугай”, БСШУ-ы сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2006 оны 379/341 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан журмын үдийн цайны цэс зохиоход тавигдах шаардлагын 4.7 “Печень, бялуу, шоколад, чихэр зэрэг чихэрлэг бүтээгдэхүүн, давсалсан самар, мөхөөлдөс, түргэн хоол, хийжүүлсэн ундаа оруулахгүй байх”, 5.1 “Хүнсний үйлдвэрлэл явуулах зөвшөөрөлтэй, улсын мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт гаргуулсан байх”, 5.2

*“Нийлүүлэхээр санал болгож буй бүтээгдэхүүнийг эрүүл ахуйн, аюулгүй байдлын шинжилгээнд бүрэн хамруулсан байх”* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Үүнд:

- ✓ Сүхбаатар сумын 1-р сургууль 1.3 сая төгрөгөөр,
- ✓ Цагааннуур сумын сургууль 4.2 сая төгрөгөөр зардлыг хэтрүүлж, үдийн цайны цэсэнд печень, чихэр, чокойпай зэрэг 1.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн оруулсан, 6,4 сая төгрөгийн махыг зах зээлийн үнээс өндөр үнээр бэлтгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

**19.** Хүдэр сум “Байгаль хамгаалах сан”-гийн зардлаас хөрөнгө худалдан авах, төсвийн байгууллагуудын тохижилт, засварын зардалд зарцуулах зэргээр 25.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байгаа нь МУ-ын Тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2.1-2.8 дахь заалтууд, Засгийн газрын 2014 оны 43 тогтоолоор батлагдсан “*Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам*”-ын 3-р зүйлийг бүхэлд нь зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

**20.** Нийт хамт олон, бүрэн бүрэлдэхүүнээр нь гадаад, дотоодын сургалтад хамрагдах нэрийдлээр гадаад улс орнууд болон Улаанбаатар хотын хавтгайруулсан томилолт, унаа, байр хоолны зардалд нийт 60.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*”, ЗГ-ын 2014 оны 147 дугаар тогтоолын 7-д “*хурал, сургалт, зөвлөгөөний давтамжийг багасгах, зайлшгүй хийх тохиолдолд төлөөгчдийн тоог цөөн, оновчтой, богино хугацаанд хийхээр эсвэл цахим хэлбэрээр зохион байгуулах*” гэсэн заалтуудыг зөрчиж байна. Үүнд:

- ✓ Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг Хонконг-Макао чиглэлээр аялал зугаалгын гэрээгээр аялуулахад 42.9 сая төгрөгийн,
- ✓ Алтанбулаг сумын төсөвт байгууллагууд Улаанбаатар хотод сургалтад хамрагдахад 7.0 сая төгрөгийн,
- ✓ Сүхбаатар сумын ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ-ы ажиллагсдыг БНХАУ-д аялуулахад 10.2 сая төгрөгийн,

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

**21.** Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн дэргэдэх Хүүхдийн ордны морин хуурын дугуйлангийн сурагчдыг тогтлолтын иж бүрэн хувцсаар хангахад 6.4 сая төгрөгийн, 7 сумдыг бөхийн дэвжээ, бөхийн өмсгөл хэрэглэл, гарын авлагаар хангах зориулалтаар 22.4 сая төгрөгийн зэрэг нийт 28.8 сая төгрөгийн, Хушаат сум засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж худалдан авахад 1.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлсэн нь Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “*Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам*”-ын 15 дахь “*энэ журмын 2.1, 2.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно*” заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж өгөв.

## Материаллаг бус дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

1. Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагууд санхүүгийн тайланд 13.5 сая төгрөгийн орлогыг дутуу, 29.7 сая төгрөгийн орлогыг илүү тайлагнасан нь Сангийн сайдын 388-р тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 2.3, 2.5 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд Иж бүрэн байх, Тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.Үүнд:

- ✓ Аймгийн ИТХ шатахууны урамшууллын 0.1 сая төгрөгийн орлогыг дутуу,
- ✓ Аймгийн ЗДТГ 27.6 сая төгрөгийн орлогыг илүү,
- ✓ Аймгийн Орон нутгийн өмчийн алба 20.4 мянган төгрөгийн шатахууны урамшууллын орлогыг дутуу,
- ✓ ГХБХБГ 0.1 сая төгрөгийн өөрийн орлогыг илүү,
- ✓ Баруунбүрэн сумын СХСангийн санхүүгийн тайланд 2.0 сая төгрөгийн орлогыг илүү тусгасан.
- ✓ Орхонтуул сумын төсөвт байгууллагууд 2.0 сая төгрөгийн урьд оны төсвийн хэмнэлтийн болон СХСангаас олгосон зээлийн хүүгийн орлогыг дутуу тусгасан.
- ✓ Сайхан сум СХСангаас олгосон зээлийн хүүгийн 11.3 сая төгрөгийн орлогыг дутуу тусгасан.
- ✓ Түшиг сумын төсөвт байгууллагууд 0.1 сая төгрөгийн орлогыг дутуу тусгасан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж, зөвлөмж өгөв.

2. Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагууд анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар нийт 75.9 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна. Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2, 7.1, 7.7 дахь заалтуудтай нийцээгүй, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.Үүнд:

- ✓ Аймгийн ИТХ 2.1 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн ЗДТГ 11.8 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн ГХБХБГ 0.9 сая төгрөгийн,
- ✓ Баянгол сумын төсөвт байгууллагууд 5.6 сая төгрөгийн,
- ✓ Ерөө сумын төсөвт байгууллагууд 15.8 сая төгрөгийн,
- ✓ Орхон сумын төсөвт байгууллагууд 1.3 сая төгрөгийн,
- ✓ Орхонтуул сумын төсөвт байгууллагууд 10.2 сая төгрөгийн,
- ✓ Сүхбаатар сумын төсөвт байгууллагууд 7.8 сая төгрөгийн,
- ✓ Түшиг сумын төсөвт байгууллагууд 6.3 сая төгрөгийн,
- ✓ Мандал сумын төсөвт байгууллагууд 6.9 сая төгрөгийн,
- ✓ Зүүнбүрэн сумын төсөвт байгууллагууд 0.1 сая төгрөгийн,
- ✓ Хушаат сумын төсөвт байгууллагууд 7.1 сая төгрөгийн,

3.Орон нутгийн төсөвт болон тусгай шилжүүлгийн байгууллагууд зардлын зүйл хооронд нийт 18.8 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан боловч санхүүгийн тайланд гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэхь “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах ” гэсэн заалтуудтай нийцээгүй, мөн Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал, Толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Аймгийн нэгдсэн музей 0.1 сая төгрөгийн,
- ✓ Алтанбулаг сумын төсөвт байгууллагууд 4.8 сая төгрөгийн,
- ✓ Мандал сумын төсөвт байгууллагууд 13.4 сая төгрөгийн,
- ✓ Орхонтуул сумын төсөвт байгууллагууд 0.5 сая төгрөгийн,

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийж, зөвлөмж өгөгдсөн байна.

4. УСНББОУС-12 “Бараа материал”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг бүртгэлийн үйл ажиллагаанд бүрэн мөрдөөгүйгээс бараа материал, үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлттэй холбоотой нийт 1,200.5 сая төгрөгийн алдаа илэрсэн нь Оршин байх, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Аймгийн ЗДТГ бараа материалын бүртгэлтэй холбоотой 37.9 сая төгрөгийн, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 19.0 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн Орон нутгийн өмчийн алба бараа материалын бүртгэлтэй холбоотой 2.2 сая төгрөгийн, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 0.5 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн Нэгдсэн музей үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 75.0 мянган төгрөгийн,
- ✓ Аймгийн номын сан үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 0.4 сая төгрөгийн,
- ✓ Сэлэнгийн долгио чуулга нь үндсэн хөрөнгийн холбоотой 1.8 сая төгрөгийн,
- ✓ Алтанбулаг сумын төсөвт байгууллагууд 22.4 сая төгрөгийн,
- ✓ Баруунбүрэн сум үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 9.0 сая төгрөгийн,
- ✓ Ерөө сумын төсөвт байгууллагууд 144.0 сая төгрөгийн,
- ✓ Мандал сумын төсөвт байгууллагууд бараа материалын бүртгэлтэй холбоотой 2.1 сая төгрөгийн, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 191.9 сая төгрөгийн,
- ✓ Хүдэр сумын төсөвт байгууллагууд бараа материалын бүртгэлтэй холбоотой 8.6 сая төгрөгийн, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 144.8 сая төгрөгийн,
- ✓ Орхонтуул сумын төсөвт байгууллагууд бараа материалын бүртгэлтэй холбоотой 4.6 сая төгрөгийн, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 3.7 сая төгрөгийн,
- ✓ Сайхан сумын төсөвт байгууллагууд үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 294.1 сая төгрөгийн,
- ✓ Сүхбаатар сумын төсөвт байгууллагууд үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 230.0 сая төгрөгийн,
- ✓ Түшиг сумын төсөвт байгууллагууд бараа материалын бүртгэлтэй холбоотой 1.9 сая төгрөгийн, үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 8.2 сая төгрөгийн,
- ✓ Цагааннуур сумын төсөвт байгууллагууд бараа материал үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 43.9 сая төгрөгийн,
- ✓ Зүүнбүрэн сумын төсөвт байгууллагууд үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 18.5 сая төгрөгийн,
- ✓ Хушаат сумын төсөвт байгууллагууд үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 10.9 сая төгрөгийн,

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж, аудитын зөвлөмж өгөв.

5. Төсөвт байгууллагууд мөнгөн хөрөнгө, бараа материалын орлого, зарлагыг нэгтгэсэн дүнгээр санхүүгийн бүртгэлд тусгасан, мөн шатахууны зарцуулалтад жолоочийн тооцооны хуудсыг бүртгээгүй зэрэг нийт 108.2 сая төгрөгийн алдаа зөрчил гаргасан байна. Энэ нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д “Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ”, Санхүү, Эдийн засгийн сайд, ҮСГ-ын даргын хамтарсан 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх

хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар” –ын 6.4 дэхь заалтуудтай нийцэгүй, Иж бүрэн, Толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.Үүнд:

- ✓ Баянгол сумын төсөвт байгууллагууд 10.3 сая төгрөгийн,
- ✓ Мандал сумын төсөвт байгууллагууд 2.9 сая төгрөгийн,
- ✓ Түшиг сумын төсөвт байгууллагууд 28.3 сая төгрөгийн,
- ✓ Цагааннуур сумын төсөвт байгууллагууд 27.3 сая төгрөгийн,
- ✓ Хушаат сумын төсөвт байгууллагууд 39.4 сая төгрөгийн,

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж, зөвлөмж өгөв.

6.Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд санхүүгийн тайланд 193.7 сая төгрөгийн авлагыг, 3.1 сая төгрөгийн өглөгийг зөрүүтэй тусгасан, 11.3 сая төгрөгийн тогтмол зардлыг гэрээ, нэхэмжлэхийн баримтгүйгээр шилжүүлж, жилийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ МУ-ын НББ-ийн тухай хуулийн 7.7 “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 19.1.4 “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэн, 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Үнэн зөв, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.Үүнд:

- ✓ Аймгийн номын сан 0.3 сая төгрөгийн авлагыг дутуу,
- ✓ Ерөө сумын төсөвт байгууллагууд 0.7 сая төгрөгийн өглөгийг дутуу,
- ✓ Мандал сумын төсөвт байгууллагууд 0.7 сая төгрөгийн авлагыг дутуу,
- ✓ Шаамар сумын төсөвт байгууллагууд 1.3 сая төгрөгийн авлага, 0.2 сая төгрөгийн өглөгийг дутуу,
- ✓ Хүдэр сумын төсөвт байгууллагууд 0.3 сая төгрөгийн авлага, 2.1 сая төгрөгийн өглөгийг дутуу,
- ✓ Сайхан сум СХСангаас олгосон зээлийн авлагыг 18.3 сая төгрөгөөр дутуу, хүүгийн авлагыг 15.4 сая төгрөгөөр илүү,
- ✓ Түшиг сум СХСангаас олгосон зээлийн 156.1 сая төгрөгийн авлагыг дутуу,
- ✓ Хушаат сум СХСангаас олгосон зээлийн 1.4 сая төгрөгийн авлагыг дутуу,
- ✓ Цагааннуур сумын сургууль цэвэр, бохир усны зардлын 11.3 сая өглөгийг гэрээ нэхэмжлэхийн баримтгүй шилжүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж, зөвлөмж өгөв.

7.Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, 2008 оны 352 дугаар тушаалаар батлагдсан заавар журмын холбогдох заалтуудыг мөрдөөгүйгээс ажил гүйлгээг мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардлаар бүртгэсэн, дансны ангилал буруу хуримтлуулан бүртгэсэн зэрэг нийт 1,394.6 сая төгрөгийн алдаа илэрлээ. Үүнд:

- ✓ Аймгийн ЗДТГ 568.5 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн орон нутгийн өмчийн алба 16.3 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн ГХБХБГ 293.0 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн худалдан авах ажиллагааны алба 2.5 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн нэгдсэн музей 1.0 сая төгрөгийн,

- ✓ Аймгийн номын сан 0.5 сая төгрөгийн,
- ✓ Баянгол сумын төсөвт байгууллагууд 164.1 сая төгрөгийн,
- ✓ Ерөө сумын төсөвт байгууллагууд 64.8 сая төгрөгийн,
- ✓ Орхон сумын төсөвт байгууллагууд 51.5 сая төгрөгийн,
- ✓ Мандал сумын төсөвт байгууллагууд 35.0 сая төгрөгийн,
- ✓ Сант сумын ЗДТГ нь 0.1 сая төгрөгийн,
- ✓ Сайхан сумын төсөвт байгууллагууд 32.9 сая төгрөгийн,
- ✓ Сүхбаатар сумын төсөвт байгууллагууд 22.0 сая төгрөгийн,
- ✓ Шаамар сумын төсөвт байгууллагууд 5.0 сая төгрөгийн,
- ✓ Хүдэр сумын төсөвт байгууллагууд 8.6 сая төгрөгийн,
- ✓ Түшиг сумын төсөвт байгууллагууд 25.1 сая төгрөгийн,
- ✓ Цагааннуур сумын төсөвт байгууллагууд 58.8 сая төгрөгийн,
- ✓ Жавхлант сумын төсөвт байгууллагууд 14.1 сая төгрөгийн,
- ✓ Зүүнбүрэн сумын төсөвт байгууллагууд 24.0 сая төгрөгийн,
- ✓ Хушаат сумын төсөвт байгууллагууд 6.8 сая төгрөгийн

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

8.Ерөө сумын ЗДТГ, Сум дундын Ой анги зэрэг байгууллагууд хөрөнгө, бараа материалын жилийн эцсийн тооллого хийгээгүй, тооцоо нийлсэн акт үйлдэж авлага, өглөгийг баталгаажуулаагүй байна. Энэ нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 11.2.1 "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийнэ", 9.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" гэсэн заалтуудтай нийцээгүй, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУ-ын НББ-ийн тухай хуулийн дагуу жил бүр комисс томилж үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийх, авлага, өр төлбөрөө Тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх талаар зөвлөмж өгсөн.

9.Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан нь тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 10.2. "Санхүүгийн тайлан дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна: ..." 10.2.5. "шаардлагатай бусад нэмэлт тодруулга" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

## **10.2 УЛС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР:**

**Үр дагавар:** Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын явцад улс, орон нутгийн хөрөнгө оруулалттай холбоотой нийт 107.0 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч, уг зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

### **Материаллаг хэмжээний дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:**

1. Мандал сум орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас төсөвт сууж батлагдаагүй төсөл, арга хэмжээ буюу Хүүхэд залуучуудын соёл спорт цогцолборын гадна тохижилтын ажлыг гүйцэтгүүлэхэд "Би-И-Эс-Эл" ХХК-тай шууд гэрээ байгуулж 10.0 сая

төгрөгийн ажлыг гүйцэтгүүлсэн байна. Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 41-р зүйлийн 41.2.2 “*батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*” 42 дугаар зүйлийн 42.7-д “*Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгаагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд 6 сумын соёл-эдийн засгийн өдрүүд арга хэмжээнд 36.0 сая төгрөг, Сэлэнгэ-Ургац 2014 арга хэмжээнд 30.0 сая төгрөг, нээлттэй хаалганы арга хэмжээнд 25.0 сая төгрөг зэрэг нийт 91.0 сая төгрөгийн урсгал зардлыг батлуулж, гүйцэтгэлээр 83.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэхь “*Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

3. Зүүнбүрэн сумын соёлын төвийн их засварын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөөгүй байхад улсын комисс ашиглалтад хүлээн авсан тухай 38/2014 тоот актыг хуурамчаар үйлдэн санхүүжилтийн үлдэгдэл 6.0 сая төгрөгийг Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын дансанд шилжүүлсэн нь ЗГ-ын 2012 оны 151 тоот тогтоолоор баталсан “*Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм-ийн 4.17.7 дахь*” *Комиссын гишүүд мэргэжлийнхээ чиглэлээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулсны дараа энэхүү дүрмийн 2-р хавсралтад заасан актад гарын үсэг зурж баталгаажуулна*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

### **10.3 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР:**

Үр дагавар: Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын явцад Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой нийт 769.3 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс: 2.4 сая төгрөгийн зөрчилд хөрөнгө нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 766.9 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

#### **Материаллаг хэмжээний дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:**

1. ОНХСангийн хөрөнгийг иргэдийн санал аваагүй, санал авч эрэмбэлсэн боловч ирцийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэн, санхүүжүүлсэн нийт 553.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 “*орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ*”-г санхүүжүүлэхийг хориглоно гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Сант сум иргэдийн санал аваагүй 5 төрлийн 25.4 сая төгрөгийн ажлыг,
- ✓ Сүхбаатар сум иргэдийн санал аваагүй 2 төрлийн 57.3 сая төгрөгийн ажлыг,
- ✓ Орхонтуул сум иргэдийн санал аваагүй 3 төрлийн 79.0 сая төгрөгийн ажлыг,
- ✓ Жавхлант сум иргэдийн санал аваагүй 1 төрлийн 10.0 сая төгрөгийн ажлыг,
- ✓ Зүүнбүрэн сум иргэдийн санал аваагүй 1 төсөл арга хэмжээний 39.4 сая төгрөгийн ажлыг,

- ✓ Хушаат сум иргэдийн санал аваагүй 9 төсөл арга хэмжээний 158.5 сая төгрөгийн ажлыг,
- ✓ Түшиг сум иргэдийн саналаар баталгаажаагүй 8 төрлийн 184.3 сая төгрөгийн ажлыг, *15 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа 2 компанид үнийн санал авах урилга хүргүүлсэн нь МУ-ын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33.2.1 дэхь заалттай нийцэхгүй байна /*

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

**2.** ОНХСангийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нийт төсөвт өртгийг хувааж, гүйцэтгэгчийг нээлттэй тендерээр бус харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан, харьцуулалтын аргаар хийх ёстой худалдан авалтыг шууд гэрээгээр гүйцэтгэсэн зэрэг нийт 114.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь МУ-ын ТБОНӨХБАҮХТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь *“Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Шаамар сум 2013-2014 дамжин хэрэгжсэн 108.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй наадмын талбайн ажлын төсөвт өртгийг хуваан харьцуулалтын аргаар “Таванхан” ХХК-ийг сонгон шалгаруулж, 2014 онд 35.0 сая төгрөгийн ажлыг мөн тус компаниар гүйцэтгүүлсэн байна.
- ✓ Сайхан сум спорт заалны засварын 2014-2015 он дамжин санхүүжигдэх 85.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг 2 хувааж, 2014 онд санхүүжигдсэн 64.3 сая төгрөгийг үндэслэн харьцуулалтын аргаар “Юнимаг” ХХК -ийг гүйцэтгэгчээр шалгаруулсан бөгөөд 2015 онд санхүүжигдэх 20.7 сая төгрөгийн ажлыг тус компанитай нэмэлт гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
- ✓ Зүүнбүрэн сум Мангирт багийн “иргэний танхим байгуулах” 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын бус шууд гэрээ байгуулж сонгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага болон зөвлөмж хүргүүлээ.

**3.** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг хүлээн авсан комиссын актууд гараагүй байхад санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн нийт 24.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь МУ-ын Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан *“Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтын журам”-ын 3.5 дахь заалтийг зөрчиж байна.* Үүнд:

- ✓ Ерөө сум 10.0 сая төгрөгөөр хөдөлгөөнт эргүүлийн автомашиныг шууд гэрээ байгуулж худалдан авахдаа хөрөнгө хүлээн авсан комиссын акт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн,
- ✓ Цагааннуур сум гудамж, хэсэг, айл өрхийн хаягжилтын ажлыг хүлээн авсан комиссын акт гараагүй байхад 4.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн,
- ✓ Жавхлант сум хогийн төвлөрсөн цэг цэвэрлэх ажлыг хүлээн авсан комиссын акт гараагүй байхад 9.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн,

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар менежментийн захидал болон албан шаардлага хүргүүлээ.

**4.** Орхон сум орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 0.7 сая төгрөгийг ИТХ-аар хэлэлцүүлж, төсвийн тодотгол хийлгэлгүйгээр ОНХСангийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан, төсөвт сууж батлагдаагүй ажил болох замын тэмдэг, тэмдэглэгээний 0.2

сая төгрөгийн ажлыг санхүүжүүлсэн байна.Эдгээр зөрчил нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 41.2.2 "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 57.3 "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна", 60.3.6 дахь "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг зарцуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн.

5. Сайхан сум ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Дулаан орц" хөтөлбөрийн гүйцэтгэгч "Өлзийт хөтөл" ХХК-д 1.4 сая төгрөгийг, Хушаат сумын сургууль, эмнэлгийн цэвэр бохир усны шугамын засварын ажлын гүйцэтгэгч "Мөнгөн өргөө" ХХК-д 0.6 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон, баг бүрт хүүхэд, залуучуудын тоглоомын талбай байгуулах ажлын тендерийн хэмнэлтийн 0.4 мянган төгрөгийг суутган тооцолгүйгээр "Хөшөө чулуу" ХХК-д илүү олгосон зэрэг нийт 2.4 сая төгрөгийг илүү шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд авлага үүсгээгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 290 тоот тушаалаар батлагдсан журмын -ын 3.25 " барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно", НББ-ийн тухай хуулийн 9.1"ААНэж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Бүртгэлд тусгаагүй авлагыг санхүүгийн тайланд тусгуулж, илүү шилжүүлсэн авлагыг буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

6. Баруунбүрэн сум ОНХСангаас сумын 90 жилийн ойн медаль, тэмдэгний үнэнд 5.0 сая төгрөг зарцуулсан байгаа нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.3 дахь "ОНХСангийн хөрөнгийг " үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардалд зарцуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага болон зөвлөмж хүргүүлээ.

7.Цагааннуур суманд орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний тендерийн баримт материал бүрдүүлэлт, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой 68.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Сангийн сайдын 2013 оны 125 дугаар тушаалаар батлагдсан "Тендерийн жишиг баримт батлах" тухай журмын холбогдох заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Тус бүр нь 12.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2, 3-р багийн тоглоомын талбайн тохижилтын ажил /нийт 24.8 сая төгрөг / , бүдүүний гүүрийн өндөрлөг засварын 22.4 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан тендерийн материал нь баримтаар нотлогдохгүй байна.
- ✓ 21.0 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгийн бохирын цооног засварлах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгчийг хэрхэн сонгосон талаарх баримтгүй, уг ажлыг хийсэн "Есөн-нуур баялаг" ХХК нь тусгай зөвшөөрөлгүй байна.

#### **10.4 СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР:**

**Үр дагавар:** Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитын явцад Аймаг хөгжүүлэх сантай холбоотой нийт 310.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 10.5 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 300.0 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

**Материаллаг хэмжээний дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:**

1. Сэлэнгэ аймгийн хөгжлийн сангаас аймгийн ИТХ-ын 2014 оны 07-р сарын 07-ны өдрийн 47 тогтоолоор 300.0 сая төгрөгийг ХХОАТ-ын буцаан олголтын санхүүжилтэд зарцуулсан нь МУ-ын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 27<sup>1</sup>.6 дахь “буцаан олгох албан татвар нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн жилд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 20 хувиас хэтрэхгүй байна”, “Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2, 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3, 4.4 дэхь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Уг алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгөв.

**Материаллаг бус дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:**

1. Бүртгэл тооцооллын алдаанаас болж 10.5 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгасан нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэхь “ анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийж, зөвлөмж өгөв.

**10.5 ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ТАЛААР:**

**Үр дагавар:** ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар нийт 403.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс материаллаг хэмжээний 16.5 сая төгрөгийн материаллаг хэмжээний, 386.7 сая төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчил илэрсэн. Үүнээс 116.8 сая төгрөгийн алдааг залруулж, 286.7 сая төгрөгийн алдааг залруулах аудитын зөвлөмжийг өгсөн байна.

**Материаллаг хэмжээний дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:**

1.“Туулын хишиг” ОНӨААТҮГ нь сумын ЗДТГ, цэцэрлэг, эмнэлгийн ус, халаалтын төлбөрийг гэрээнд тусгагдсан дүнгээс 1.7 сая төгрөгөөр илүү нэхэмжлэн авч тайлант жилийн орлогоор бүртгэсэн, Цагдаагийн байр, ХААН банк, Төрийн банк, Төмөр замын дэлгүүрүүдтэй гэрээ байгуулахгүйгээр халаалтаар хангаж төлбөр тооцоо барагдуулсан, өглөг авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг нь Халаалтын гэрээний 4.1 “Төлбөр тооцоо хийх журам”, МУ-ын НББ-ийн тухай хуулийн 7.1 дэхь “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид халаалтын гэрээг үндэслэн бодит гүйцэтгэлээр төлбөрийг нэхэмжилж байх албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгсөн.

2.“Сэлэнгэ үржлийн цөм сүрэг” ОНӨААТҮГ нь тайлант онд байгууллагын төсвөөс сумын сайн малчинд 50.0 мянган төгрөгийн тэтгэмж, Баруунбүрэн сумын нутгийн зөвлөлийн

уулзалтын зарын үнэнд 29.4 мянган төгрөгийг төлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байгаа нь МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага болон зөвлөмж хүргүүлээ.

**3.** “Сэлэнгэ зүүнхараа” ОНӨААТҮГ нь төмөр замын 1-р ангиас нийлүүлсэн усны хэрэглээний төв тоолуурын заалт болон айл өрх, албан байгууллагуудын хэрэглэсэн усны хэрэглээний тоолуурын заалтын хоорондын зөрүүгээр 4.7 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь, Үнэн зөв байдал, Оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрхи тоолуурын заалтын зөрүүнээс үүссэн 4.7 сая төгрөгийн тодорхой бус авлагыг төмөр замын 1-р анги болон сумын иргэдийн хуралд уламжлан шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгсөн байна.

**4.** “Цант-Орхон” ХХК нь сумын Нэгдсэн эмнэлэгт хуурамч нэхэмжлэх өгч ХААН банкны харилцах дансаар дамжуулан 10.0 сая төгрөгийг тухайн байгууллагад бэлнээр гаргаж өгсөн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Харилцах дансанд гүйлгээ андуурч орж ирсэн гүйлгээг буцааж байх, хуурамч баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх, уг алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн байна.

#### **Материаллаг бус дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:**

**1.** “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ нь жилийн эцсийн санхүүгийн тайланд 38.2 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг өглөгийн дансанд бүртгэсэн, 182.8 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 19.1.4, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 2-р бүлгийн 8 дахь заалтуудтай нийцээгүй, Хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

**2.** “Сэлэнгэ энерго” ОНӨААТГазрын санхүүгийн тайлангаарх өглөгийн үлдэгдлүүд НДШ, ХХОАТ, НӨАТ-ын тайлангуудаарх үлдэгдлүүд хоорондоо зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Үүнд: НДШ-ийн өглөг 0.3 сая төгрөгөөр, ХХОАТ-ын өглөг 0.1 сая төгрөгөөр, НӨАТ-ын өглөгийн үлдэгдэл 1.9 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй байна. Мөн тайлант онд худалдан авсан бараа материалын 13.1 сая төгрөгийн НӨАТ-ын падааныг бүрдүүлж татварын буцаалтанд тооцуулаагүйгээс НӨАТ-ын өглөг өмнөх оноос өссөн байна. Эдгээр зөрчил нь МУ-ын НДШ, ХХОАТ, НӨАТ-ын тухай хуулиудын холбогдох заалтуудтай нийцээгүй, Эрх ба үүрэг, Оршин байх, Иж бүрэн гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

**3.** “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь санхүүгийн тайланд техник хяналтын зардлын 32.1 сая төгрөгийн өөрийн орлогыг дутуу тусгасан, 4.0 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг тайлант жилийн зардалд бүртгээгүйгээс урамшууллын 1.6 сая төгрөгийн, ХХОАТ-ын 0.4 сая төгрөг, НДШ-ийн 0.9 сая төгрөгийн зэрэг нийт 2.9 сая төгрөгийн өглөг

үүсгэж, санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 9 дүгээр зүйлийн 9.1, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын холбогдох заалтуудтай нийцээгүй, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж, зөвлөмж өгөв.

4. “Туулын хишиг” ОНӨААТҮГ ашиглалтын жил нь дууссан 1.3 сая төгрөгийн өртөг бүхий тавилга эд хогшлын элэгдлийн зардлыг 1.8 сая төгрөгөөр илүү тооцож бүртгэсэн, 3.9 сая төгрөгийн ажил гүйлгээг мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардлаар бүртгэсэн байна. Эдгээр нь Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын холбогдох заалтуудтай, Үнэлгээ, Хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж, зөвлөмж өгөв.

5. “Гавшгай-Ус” ХХК- нь 2014 онд худалдан авсан 19.5 сая төгрөгийн бараа материалын падааны дүнг засварлаж, хүчин төгөлдөр бус баримтаар бүртгэлд тусгасан, тайлант онд ХХОАТ төлөгч иргэнээс худалдан авалтыг гүйцэтгэхдээ 0.3 сая төгрөгийн татварыг суутган тооцож, тайлагнаагүй байна. Эдгээр нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-дахь заалт “...санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, 7 дугаар зүйлийн 7.1-д заасан “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, мөн хуулийн 7.5 дахь заалт “...Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, ХХОАТ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, 12 дугаар зүйлийн 12.1.2, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэхь заалтуудтай нийцээгүй, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал, Иж бүрэн гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ татварын тухай хуулийн дагуу харьяалагдах татварын албанд цахим болон цаасан хэлбэрээр мэдээлэх зөвлөмж өгөв.

6. “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ- нь тайлант онд худалдан авсан 3.3 сая төгрөгийн бараа материалын үнийн дүнгээс татвар суутган аваагүй, цалингаас суутгасан 0.3 сая төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй, үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг өмнөх онтой зэрэгцүүлж тайлагнаагүй байна. Энэ нь МУ-ын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтуудтай нийцээгүй, Эрх бат үүрэг, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уг зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

7. “Сэлэнгэ зүүнхараа” ОНӨААТҮГ нь үндсэн хөрөнгө акталснаас үүссэн 36.6 сая төгрөгийн гарзыг татвар ногдох орлогоос хасч тооцсон, 5.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн орлогыг бүртгээгүй, дулааны авлагыг 2.8 сая төгрөгөөр өмнөх оноос нэмэгдүүлсэн, хангамжийн материалын 8.8 сая төгрөгийн орлого, зарлагыг материалын тайланд нэр төрлөөр ангилж бүртгээгүй, тайлант онд сумын ИТХ-аар жилийн орлого, зарлагын төлөвлөгөөг батлуулаагүй зэрэг алдаа, зөрчил гаргасан байгаа, Үнэн зөв байдал, Иж бүрэн байх, Толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж, зөвлөмж өгөгдсөн байна.

8.Цант-Орхон” ХХК нь анхан шатны баримтын дутуу 10.0 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байгаа нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх, уг алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгсөн байна.

9.”Урсгал-Ус” ХХК нь тайлант онд 3 иргэнээс 0.4 сая төгрөгийн бараа материал худалдан авахдаа иргэний орлогын дэвтэрт бичилт хийж баталгаажуулсан боловч татварын албанд тайлагнаагүй, үндсэн хөрөнгө худалдан авсан 22.7 сая төгрөгийн зардлыг мөнгөн гүйлгээний тайланд бүртгээгүй байна. УСНББОУС -2 “Мөнгөн гүйлгээний тайлан”, МУ-ын ХХОАТатварын тухай хуулийн 12 зүйлийн 2.1.2 дэхь заалтуудтай нийцээгүй, Эрх ба үүрэг, Иж бүрэн байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийж, зөвлөмж өгсөн байна.

### **11.Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад залруулагдаагүй 2,188.2 сая төгрөгийн зөрчил илэрснийг менежментийн захидалд дэлгэрэнгүй байдлаар орууллаа.

### **12.Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар нийт 12,394.4 сая төгрөгийн авлага, 6,586.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь өмнөх оноос авлага 336.2 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар, өглөг 1,108.4 сая төгрөг буюу 20.2 хувиар тус тус өссөн байна. Иймд төсвийг зохистой удирдлагаар хангаж, авлага, өглөгийг бууруулах, барагдуулах, он удаан жил дамжсан, хариуцах эзэн нь тодорхой бус найдваргүй авлагыг холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэр гаргуулж тайлан балансаас цэвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

- *Аймгийн төсвөөс 1990-2002 оны хооронд аж ахуй эрхлэх, өвсний нөөц, хүнсний хөтөлбөр зэрэг арга хэмжээнд олгосон 48.8 сая төгрөгийн, 1993 онд олгосон уринш боловсруулалтын 199.9 сая төгрөгийн, 2001 онд улсын нөөцөөс иргэд, аж ахуйн нэгжүүдэд хадлан тэжээл бэлтгэхэд олгосон 45.7 сая төгрөгийн, өрхийн амжиргаа дэмжих төслөөс олгосон 0.3 сая төгрөгийн зээлийн авлага, аж ахуй нэгж байгууллагаас авах 162.2 сая төгрөгийн татварын авлага зэрэг нийт 277.1 сая төгрөгийн авлага, “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-аас авах 744.5 сая төгрөгийн авлага.*
- *Сэлэнгэ аймгийн хөгжлийн сангаас олгосон 2009 оны 17 зээлдэгчийн 541.5 сая төгрөгийн, 2010 оны 15 зээлдэгчийн 260.8 сая төгрөгийн, 2011 оны 41 зээлдэгчийн 526.7 сая төгрөгийн зэрэг нийт 2,114.3 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн нь Аймгийн ИТХ-ын 2013 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ аймгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.2.7, 4.2.8, зээлийн гэрээний 3.2 дахь “зээлийг гэрээгээр тохиролцсон хугацаанд үл маргах журмаар төлж барагдуулах үүрэгтэй ” гэсэн заалтуудыг зөрчиж байна. Хэдийгээр зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтрүүлсэн зээлдэгчдээс*

2014 онд нийт 20 зээлдэгчийг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, төлөгдөөгүй зээлийг нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ авч байгаа ч төлөлт нь удаан байгаад анхаарч тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

- Сумдын хөгжүүлэх сан, Мандал сумын Түнхэл хөгжүүлэх сан, Хэрх хөгжүүлэх сангуудаас 2011-2014 оны хооронд олгосон зээлээс нийт **1,104.1** сая төгрөг / Хавсралт -1 / эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байгаа нь МУ-ын ЗГ-ын 2011 оны 134 тоот тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.7 “ Иргэн, ААН олгосон зээлийн хөрөнгө, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд Сум хөгжүүлэх сангийн дансанд эргэн төлнө” гэсэн заалтыг зөрчиж байна.

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 15 нэр төрлийн 2,169.0 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгө оруулалтын ажлуудыг бүртгэлд тусгаагүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 8 дугаар зүйлийн 8.6 дахь “ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчит бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэлд тусгуулж байх шаардлагатай байна.

### **13.Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Аймгийн ТЕЗ-ийн 2014 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар гүнзгийрүүлэн шалгахад цаг хугацаа, хүн, хүчний хувьд боломжгүй байсан “**Сэлэнгэ аймгийн хөгжлийн сан**”-гаас олгосон зээлийн эргэн төлөлт, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, ОНӨААТҮГ-уудын хөрөнгө санхүүгийн байдал, Хушаат, Хүдэр сумын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийж, гүнзгийрүүлэн шалгах.

### **14.Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Аудитын явцад нийт 5,634.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, материаллаг хэмжээний 2,188.2 сая төгрөгийн, материаллаг бус 3,446.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ.Үүнээс: Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой 3,176.3 сая төгрөгийн алдааг залруулж, 45.3 сая төгрөгийн зөрчилд хөрөнгө нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 1,976.2 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага, 436.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

### **15.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Аймгийн Аудитын газраас аймгийн ТЕЗ-ийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 8 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, 5 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой алдааг давтан гаргахгүй байхад зохих хяналтыг хэрэгжүүлж, нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллах.
- Хөрөнгө оруулалтын арга хэмжээг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлэх.
- ТБОНӨХБАУ худалдан авахдаа холбогдох, хууль, дүрэм, журмыг мөрдөж ажиллах.
- АИТХ-ын 2013 оны 26 тоот тогтоолоор баталсан журмын дагуу: Аймгийн хөгжлийн сангаас авсан зээлийг үр ашиггүй зарцуулсан, зээл, түүний хүүг гэрээний хугацаа хэтрүүлсэн зээлдэгчид гэрээнд заасны дагуу алданги тооцох, барьцаа

хөрөнгийг тогтоосон журмын дагуу борлуулж төсвийг хохиролгүй болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.

- Засаг даргын нөөц хөрөнгийг батлагдсан журмын дагуу зарцуулах, анхан шатны баримтын бүрдлийг хангах.

### **16.3өвлөмж:**

- Сангийн Сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан “ Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэх үлгэрчилсэн загвар”-ыг мөрдлөг болгон орон нутгийн байгууллагуудын нягтлан бодогч нараар санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг бэлтгүүлж байх.
- Нягтлан бодох бүртгэлийг НББОУС, УСНББОУС, Сангийн сайдын тушаалуудын дагуу үнэн зөв хөтөлж, жил бүрийн санхүүгийн тайланд давтан гарч буй бүртгэл хөтлөлттэй холбоотой их хэмжээний алдаа, зөрчлийг арилгах, нягтлан бодогч нарын мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх.
- Төсвийн тухай хуулийн 23-р зүйлийн дагуу улс, аймаг, сумын төсвийн орлогыг бүрдүүлэх, улсын төсвийн орлогыг аймагт, аймгийн орлогыг суманд, сумын орлогыг Ойн анги зэрэг байгууллагууд төвлөрүүлэн зарцуулж буй зөрчлийг арилгах.
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөвөөр тайлагнаж байх.
- Авлагын дансны үлдэгдэлд бүртгэлтэй он дамжсан, эзэн хариуцагч нь тодорхойгүй, найдваргүй 277.1 сая төгрөгийн авлагыг холбогдох байгууллага, албан тушаалны шийдвэр гаргуулж данснаас цэвэрлэх, Сэлэнгэ-Энерго ОНӨААТҮГ-аас авах авлагыг барагдуулах, төсвийг зүй зохистой удирдаж шинээр авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын менежерүүдийн ажлыг холбогдох журмын дагуу үнэлж, дүгнэн үр дүнгийн урамшууллыг олгохдоо холбогдох журам, зааварт нийцүүлж байх.
- Засаг даргын нөөц хөрөнгийг МУ-ын ЗГ-ын тогтоолоор батлагдсан журмын хүрээнд захиран зарцуулж, гүйцэтгэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.
- Төсвийн тухай хууль болон түүнтэй холбогдуулан гаргасан журам, зааврыг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгож, төсвийн гүйцэтгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах.
- Сумдын ТЕЗ, орон нутгийн болон төсвийн тусгай зориулалтын байгууллагуудын төсвийн шууд захирагч нарын хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг авч, хууль эрх зүйн болон арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу орон нутгийн өмчид бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах.
- Аймгийн хөгжлийн сан болон, сум хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг эргэн төлүүлэх , хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлж эргэлтэд оруулах, зээлийн үр өгөөжийг дээшлүүлэх.
- Аймгийн Аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” болон “Сөрөг” санал дүгнэлт авсан,ТЕЗ, Төсвийн шууд захирагч нар болон түүний санхүү бүртгэлийн ажилтнуудад Төрийн аудитын тухай хуулийн 28, Төсвийн тухай хуулийн 70-р зүйлийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах.

## **17.Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:**

Санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлого 110,007.4 сая төгрөгийн 2%-иар тооцож 2,200.1 сая төгрөг байна гэж үзсэн бөгөөд аудитаар 2,188.2 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн нь материаллаг байдлын түвшингээс бага байна.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журмуудын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Санхүүгийн тайлан, хавсралтууд, байгууллагын саналын хуудсыг тус тус хавсаргав.

### **АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:** ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

**БЭЛТГЭСЭН:** АХЛАХ АУДИТОР

С.БАТ-ЭРДЭНЭ

**2015.04.20**





# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## **Менежментийн захидал**

### **Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:**

#### **Асуудал 1**

Орлого.....

#### **Асуудал 2**

Авлага, өглөг.....

#### **Асуудал 3**

Бараа материал, үндсэн

хөрөнгө.....

#### **Асуудал 4, 5**

Зардал .....

#### **Асуудал 6**

Засаг даргын нөөц сан .....

#### **Асуудал 7**

Орон нутгийн хөрөнгө оруулалт.....

#### **Асуудал 8**

Орон нутгийн хөгжлийн сан .....

#### **Асуудал 9**

Аймгийн хөгжлийн сан .....

#### **Асуудал 10**

ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн талаар .

### **Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:**

#### **Асуудал 11**

Хариуцлага тооцуулах тухай .....

### **Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:**

#### **Асуудал 12**

Тайлангийн тодруулга .....

## **Менежментийн захидал**

ҮАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар нь аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Сэлэнгэ аймгийн ТЕЗ, удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан аймаг, сумын удирдлагууд, санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Орлого****Тэргүүлэх ач холбогдол №1****Ажиглалт**

-Төсөвт байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг нийт 1.9 сая төгрөгөөр тасалсан байна.

- Улсын төсөвт төвлөрүүлэх ёстой 300.1 сая төгрөгийн татварын орлогыг аймгийн болон сумын төсөвт төвлөрүүлэн зарцуулсан.

-Аймгийн төсөвт төвлөрүүлэх газрын болон хадлангийн, усны төлбөрийн нийт 17.6 сая төгрөгийн орлогыг сумын төсөвт төвлөрүүлэн зарцуулсан.

-Сумын ой анги болон Сум дундын ой ангиуд сумын төсөвт төвлөрүүлэх гоожингийн 14.4 сая төгрөгийн орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлэн зарцуулсан.

-Орхонтуул сумын ИТХ-аар батлуулалгүйгээр 1.8 сая төгрөгийн өөрийн орлогыг зарцуулж батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

-Төсөвт байгууллагууд хандив тусламжийн болон өөрийн орлогын нийт 11.9 сая төгрөгийг төрийн сангийн бүртгэлийн дансаар дамжуулалгүйгээр кассаар зарцуулж, санхүүгийн тайланд уг орлогыг дутуу тусгасан байна

- Төсөвт байгууллагууд төрийн сангийн бүртгэлийн данснаас хуурамч баримт бүрдүүлэн ажилтнуудын хувийн харилцах дансаар дамжуулан нийт 7.6 сая төгрөгийг бэлэн авч зарцуулсан байна.

Ерөө сум нь сумын хөгжлийг дэмжих сангаас олгосон зээлийн эргэн төлөлт болох 100.0 сая төгрөгийг Төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэхгүйгээр ХААН банкин дахь харилцах данснаас 35.0 сая төгрөгийг сумын 90 жилийн ойн хандивт, 10.0 сая төгрөгийг музейн тохижилтонд, 49.0 сая төгрөгийг Ерөө сумын төвд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажилд зарцуулсан байна.

**Эрсдэлүүд**

-Төсвийн хууль тогтоомж, зөрчигдөх.

**Зөвлөмж**

-МУ-ын төсвийн тухай хуульд заасан эрх үүргийн хүрээнд татварын орлогыг бүрдүүлж, зарцуулах.

**Төсвийн захирагчийн хариу**

-Төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, ашиглан шамшигдуулах.

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

<b>Асуудал 2: Авлага, өр төлбөр</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
-------------------------------------	----------------------------------

**Ажиглалт**

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцэст 26.7 сая төгрөгийн авлага, 100.0 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Цагааннуур сумын ЕБС цалингийн зардлаас бусад зардалд зориулалт бусаар зарцуулж, төсвийг зохистой удирдаагүйгээс 3.4 сая төгрөгийн авлага, 66.2 сая төгрөгийн НДШ, ХХОАТ-ын өглөг үүсгэсэн байна.

Түнхэл тосгоны ЕБС, Цэцэрлэгүүд нь оны эцэст нэмэлт санхүүжилтээр орж ирсэн тус бүрийн 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг хуурамч нэхэмжлэх бүрдүүлэн хувийн компаний харилцахаар дамжуулан бэлнээр гарган авч, жилийн эцсийн санхүүгийн тайланд үүсгэхгүй байх боломжтой 40.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Хушаат, Шаамар сумдын төсөвт байгууллагууд урьд оны санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгагдаагүй 2.0 сая төгрөгийн өглөгийг тайлант жилийн төсвөөс барагдуулсан.

**Эрсдэлүүд**

Төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах.

**Зөвлөмж**

-Төсвийг зүй зохистой удирдаж өр төлбөр, авлага үүсгэхгүй байхад анхаарч ажиллах, үүсгэхгүй байх боломжтой өр төлбөр, авлага үүсгэсэн төсвийн захирагч нарт МУ-ын Төсвийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцож сахилгын шийтгэл ногдуулах.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

<b>Асуудал 3: Үндсэн хөрөнгө, бараа материал</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
--	----------------------------------

**Ажиглалт**

Түшиг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд 7.0 сая төгрөгийн хангамжийн материал, мал амьтад, Шаамар сумын Дулаанхаан тосгоны цэцэрлэг 0.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө зэрэг байгууллагын эзэмшилд бодитойгоор оршин байхгүй хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгасан байна. Энэ нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 4.1.2, 9.1 дэхь заалтуудтай нийцэхгүй байна.

**Зөвлөмж**

- Тайлант хугацааны эцэст үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг гүйцэтгэж, санхүүгийн тайланд хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөвөөр тусгах.

**Эрсдэлүүд**

-Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

<b>Асуудал 4: Зардал /Цалин, НДШ/</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
---------------------------------------	----------------------------------

**Ажиглалт**

Цалин хөлсийг давхардуулан олгосон, тушаал шийдвэргүйгээр үр дүнгийн урамшуулал болон цалингийн нэмэгдлүүд олгосон, цалингийн санг бусад зардалд гүйлгэн зарцуулсан, ХХОАТ, НДШ-ийн суутгал тайлагналтай холбоотой зэрэг нийт **125.9 сая** төгрөгийн зөрчил илэрлээ.

**Зөвлөмж**

-Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

-Цалин, хөлсний нэмэгдлүүдийг холбогдох журмын дагуу тооцон олгож байх.

**Эрсдэлүүд**

Төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах, ашиглан шамшигдах.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 5: Зардал****Тэргүүлэх ач холбогдол №1****Ажиглалт**

ТЗШ болон орон нутгийн төсөвт байгууллагууд дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр 37.2 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, санхүүгийн тайланд гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,

Цагааннуур сумын ЗДТГазар халаалтын зардлыг бодит гүйцэтгэлээр нь бус батлагдсан төсвөөр нь шилжүүлснээс 2.4 сая төгрөгийн халаалтын зардлыг “Атартрейд” ХХК-д илүү шилжүүлсэн,

СБ сумын 1-р сургууль, Цагааннуур сумын сургуулиуд дотуур байрны хүүхдийн хоолны нормативт зардлыг хэтрүүлэн зарцуулсан, бараа материалыг зах зээлийн үнээс өндөр үнээр бэлтгэсэн зэрэг, нийт 13.6 сая төгрөгийн зөрчил гаргасан,

Хүдэр сум байгаль хамгаалах сангийн зардлаас хөрөнгө худалдан авах, төсвийн байгууллагуудын тохижилт, засварын зардалд зарцуулах зэргээр 25.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,

Орон нутгийн төсөвт байгууллагууд байгууллага, хамт олноороо сургалтанд хамрагдах нэрийдлээр УБ хот болон гадаад улс оронд аялах, зугаалахад нийт 60.1 сая төгрөгийг зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

**Эрсдэлүүд**

Төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах, холбогдох хууль, тогтоомж зөрчигдөх.

**Зөвлөмж**

- Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох газраас зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг бодитоор тайлагнах.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

<b>Асуудал 6: Засаг даргын нөөц сан</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
---	----------------------------------

**Ажиглалт**

- Аймгийн засаг даргын 2014 оны А/118 тоот захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн дэргэдэх Хүүхдийн ордны морин хуурын дугуйлангийн сурагчдыг тогтлолтын иж бүрэн хувцасаар хангахад 6.4 сая төгрөгийн, А/272 тоот захирамжаар 7 сумдыг бөхийн дэвжээ, бөхийн өмсгөл хэрэглэл, гарын авлагаар хангах зориулалтаар 22.4 сая төгрөгийн зэрэг нийт 28.8 сая төгрөгийн, Хушаат сум засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж худалдан авахад 1.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлсэн байна.

**Эрсдэлүүд**

Хууль тогтоомж зөрчигдөх, төсвийг зориулалт бусаар зарцуулах.

**Зөвлөмж**

-ЗГ-ын тогтоолоор батлагдсан журмын хүрээнд захиран зарцуулах.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

<b>Асуудал 7: Улс, орон нутгийн хөрөнгө оруулалт</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
--	----------------------------------

**Ажиглалт**

Мандал сум ОНХО-ын зардлаас төсөвт сууж батлагдаагүй төсөл, арга хэмжээ буюу Хүүхэд залуучуудын соёл спорт цогцолборын гадна тохижилтын ажлыг гүйцэтгүүлэхэд “Би-И-Эс-Эл” ХХК-тай шууд гэрээ байгуулж 10.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтанд 6 сумын соёл-эдийн засгийн өдрүүд арга хэмжээнд 36.0 сая төгрөг, Сэлэнгэ-Ургац 2014 арга хэмжээнд 30.0 сая төгрөгийг, нээлттэй хаалганы арга хэмжээнд 25.0 сая төгрөг зэрэг нийт 91.0 сая төгрөгийг батлуулж, гүйцэтгэлээр 83.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Зөвлөмж**

- Хөрөнгө оруулалтын арга хэмжээг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлэх.

Зүүнбүрэн сумын соёлын төвийн их засварын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөөгүй байхад улсын комисс ашиглалтад хүлээн авсан тухай 38/2014 тоот актыг хуурамчаар үйлдэн санхүүжилтийн үлдэгдэл 6.0 сая төгрөгийг Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-ын дансанд шилжүүлсэн нь байна.

### **Эрсдэлүүд**

Төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах.

### **Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

<b>Асуудал 8: Орон нутгийн хөгжлийн сан</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
<p><b><u>Ажиглалт</u></b></p> <p>ОНХСангийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой нийт 769.3 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Иргэдийн саналаар баталгаажуулах төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн 553.9 төгрөгийн, Сумын ОНХСангийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа төсөвт өртөгийг хувааж, гүйцэтгэгчийг нээлттэй тендерээр бус харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан, харьцуулалтын аргаар хийх ёстой худалдан авалтыг шууд гэрээгээр гүйцэтгэсэн зэрэг, нийт 114.3 сая төгрөгийн, Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг хүлээн авсан комиссын актууд гараагүй байхад санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн нийт 24.6 сая төгрөгийн, Орхон сум төсөвт сууж батлагдаагүй арга хэмжээнд 0.9 сая төгрөгийг зарцуулсан, ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгч компанид Сайхан сум 1.4 сая төгрөгийг, Хушаат сум 2 гүйцэтгэгч аж ахуй нэгжид 1.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус илүү шилжүүлсэн, Баруунбүрэн сум ОНХСангийн хөрөнгөөр сумын 90 жилийн ойн тэмдэг хийлгэхэд 5.0 сая төгрөгийг зарцуулсан,</p> <p>Цагааннуур сумын ОНХСангаар хэрэгжүүлсэн тус бүр нь 12.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2, 3-р</p>	<p><b><u>Зөвлөмж</u></b></p> <p>-Төсвийн тухай хууль, болон Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг бүрэн мөрдөж ажиллах.</p>

багийн тоглоомын талбайн тохижилтын ажил, бүдүүний гүүрийн өндөрлөг засварын 22.4 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан тендерийн материал нь баримтаар нотлогдоогүй, мөн 21.0 сая төгрөгийн өртөг бүхий цэцэрлэгийн бохирын цооног засварлах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгчийг хэрхэн сонгосон талаарх баримтгүй, уг ажлыг хийсэн “Есөн-нуур баялаг” ХХК нь уг ажлыг хийх тусгай зөвшөөрөлгүй байна.

### **Эрсдэлүүд**

Төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах.

### **Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

<b>Асуудал 9: Аймгийн хөгжлийн сан</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
--	----------------------------------

#### **Ажиглалт**

Сэлэнгэ аймгийн хөгжлийн сангаас аймгийн ИТХ-ын 2014 оны 07-р сарын 07-ны өдрийн 47 тогтоолоор 300.0 сая төгрөгийг ХХОАТ-ын буцаан олголтын санхүүжилтэнд олгосон нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.2 дахь “ төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” 1.5 дахь “хариуцлагатай байх”, Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2, 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3, 4.4 дэхь заалтуудыг тус тус зөрчиж байна.

#### **Эрсдэлүүд**

Тус сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах.

#### **Зөвлөмж**

-Сангийн хөрөнгийг зориулт бусаар зарцуулахгүй байх.

#### **Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 10: ОНӨААТҮГ-уудын нэгтгэсэн санхүүгийн тайлан**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**Ажиглалт**

ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар нийт 403.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 116.8 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 286.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнээс: 16.5 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага, 270.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Үүнд:

-”Туулын хишиг” ОНӨААТҮГ сумын ЗДТГ, цэцэрлэг, эмнэлгийн ус, халаалтын төлбөрийг гэрээнд тусгагдсан дүнгээс 1.7 сая төгрөгөөр илүү нэхэмжилэн авч тайлант жилийн орлогоор бүртгэсэн, дулаанаар хангаж буй аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулаагүй,

-”Сэлэнгэ үржлийн цөм сүрэг” ОНӨААТҮГ тайлант онд байгууллагын төсвөөс 79.4 мянган төгрөгийн хандив, шагнал урамшуулал олгосон,

”Сэлэнгэ зүүнхараа” ОНӨААТҮГ нь төмөр замын 1-р ангийн тоолуурын заалт болон айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудын хэрэглэсэн усны тоолуурын заалтын зөрүүгээр тодорхой бус 4.7 сая төгрөгийн авлага үүсгэсэн,

“Цант-Орхон” ХХК нь сумын Нэгдсэн эмнэлэгт хуурамч нэхэмжлэх өгч ХААН банкны харилцах дансаар дамжуулан 10.0 сая төгрөгийг тухайн байгууллагад бэлнээр гаргаж өгсөн зэрэг материаллаг хэмжээний зөрчлүүд илэрсэн байна.

**Эрсдэлүүд**

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, найдваргүй авлага бий болох.

**Зөвлөмж**

- ОНӨААТҮГ азруудад ТЕЗ-ийн зүгээс дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 11: Хариуцлага тооцуулах тухай****Тэргүүлэх ач холбогдол №2****Ажиглалт**

2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 4 сумдын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч “Зөрчилтэй санал дүгнэлт” 1 сумын ТЕЗ, 3 байгууллагын ТШЗ-ийн санхүүгийн тайланд “Сөрөг-санал дүгнэлт” өгөгдсөн байна.

**Зөвлөмж**

- Аймгийн аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай”, Сөрөг” санал дүгнэлт авсан ТЕЗ, Төсвийн шууд захирагч болон санхүү бүртгэлийн ажилтнуудад Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 06-р сарын 01-ний өдрийн дотор Аймгийн аудитын газарт ирүүлэх.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланг толилуулахдаа гаргадаг бодит байдлын тухай Үнэн зөв байх батламж мэдэгдлүүд зөрчигдөх эрсдэлтэй байна.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**Асуудал 12: “Тайлангийн тодруулга”****Тэргүүлэх ач холбогдол №3****Ажиглалт**

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан нь тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь МУ-ын НББ-ийн тухай хуулийн 10.2. Санхүүгийн тайлан дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна: ... 10.2.5. *“шаардлагатай бусад нэмэлт тодруулга”* гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

**Зөвлөмж**

-МУ-ын НББ-ийн тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасны санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг хийж байх.

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

---

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ:**

**ХЯНАСАН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

Огноо:

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

С.БАТ-ЭРДЭНЭ

Огноо:

<b>Асуудал 3: Зардал</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №2</b>
<b><u>ҮАГ-ын ажиглалт</u></b> Үндсэн бус үйл ажиллагааны 1.56 сая төгрөг, бусад орлогын 16.5 сая төгрөгийн орлогыг бууруулах бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.  Бичиг хэргийн 2.5 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 он 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.21 дэх заалттай нийцэхгүй байна.	<b><u>ҮАГ-ын зөвлөмж</u></b> Төсвийн тухай хуулийг мөрдөж, төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах
<b><u>Эрсдэлүүд</u></b> Улсын төсвийн орлогын төлөвлөгөө тасрах, батлагдсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах	<b><u>Төсвийн захирагчийн хариу</u></b> Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.